

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 он

Судалгааны захиалагч:	Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Судалгааг удирдсан:	Д.Энхзул МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн ахлах багш Хууль зүйн докторант
Судалгааг гүйцэтгэсэн:	О.Майцэцэг Б.Энхмарал Э.Цэлмэг Э.Мягмарнаран Б.Зүнжээ

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	6
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал	9
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох	9
1.3. Асуудал үүссэн шалтгаан нөхцлийг тодруулсан байдал	10
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ.....	11
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ.....	11
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	18
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	19
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	20
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ	27
НАЙМ. ХАВСРАЛТ	29
ЕС. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	38

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл

Ардын засгийн газрын 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолоор “Судар бичгийн хүрээлэн” байгуулагдсанаар Монгол улсад шинэ үеийн шинжлэх ухааны төв байгууллага бий болсон түүхтэй бөгөөд хожим нь Шинжлэх ухааны хүрээлэн, Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн болон өргөжин тэлсээр 1961 онд Шинжлэх ухааны Академи болон зохион байгуулагдсан юм. Монгол Улсын Их Хурлаас 1996 оны 05 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай” хуулиар шинжлэх ухааны академи нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага болохыг хуульчилсан болно.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар шинжлэх ухааны академийн шууд харьяалалд 21 эрдэм шинжилгээний хүрээлэн төв, 2 салбарын төрөлжсөн академи, 1 номын сан үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсад шинжлэх ухааны академи, түүний бүтцийн нэгжид эрх, үүрэг болгон хэм хэмжээ тогтоосон 19 гаруй хууль, 40 гаруй дүрэм, журам хүчин төгөлдөр үйлчилж байгаа болно. Эдгээр хууль тогтоомжуудаас “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль” нь шинжлэх ухааны төв байгууллага болох шинжлэх ухааны академийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжүүлэх эрх, үүргийг ерөнхий байдлаар зохицуулсан бөгөөд хуулийн зохицуулалтыг Улсын Их Хурал, Засгийн газар болон шинжлэх ухааны академийн эрх бүхий байгууллагын баталсандүрэм, журмаар илүү дэлгэрэнгүй зохицуулсан байна.

1998 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай” 55 дугаар тогтоолын хавсралтад уг бодлогын нийтлэг үндэслэлийг дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

- Монгол Улсын хөгжин дэвших нэг үндэс нь шинжлэх ухаан, технологийн давшингуй хөгжлийг хангах явдал мөн.
- Шинжлэх ухаан, технологийн дэвшил нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, оюуны баялгийг арвижуулах эх сурвалж, эдийн засгийн аюулгүй байдлын үндэс суурь мөн. Иймээс шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд төрөөс онцгой анхаарал тавина.
- Ажиллах хүч, зах зээл хязгаарлагдмал Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлтийг хангах, хүн амын амьдралын түвшин, чанарыг сайжруулахдаа шинжлэх ухаан, технологийг түлхүү хөгжүүлж, түүний ололтод тулгуурлан дэлхийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, экспортын зориулалт бүхий, шинжлэх ухааны багтаамж ихтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь экспортод чиглэсэн зах зээлийн эдийн засагтай, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах, улмаар түүний тогтвортой хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болохуйц түвшинд хүртэл нь шинжлэх ухаан, технологийн чадавхыг хөгжүүлэхэд оршино.

Түүнчлэн дээр дурдсан УИХ-ын 55 дугаар тогтоол, “Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоол зэрэгт Монгол улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр заасныг удирдлага болгон

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г баталсан байдаг.

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд “...эрдэм шинжилгээний байгууллагуудын бие даасан үйл ажиллагаа хангалтгүй, санхүүгийн эх үүсвэр олох сонирхол бага, судалгаа шинжилгээний үр өгөөж хангалтгүй”¹, “...тэргүүлэх хүрээлэн, их сургууль, судалгаа-сургалтын газрыг дэмжих, тэдгээрийн материал техникийн бааз болон боловсон хүчний чадамжийг тэргүүлэх ээлжид хөгжүүлэхэд хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх боломж өгөхгүй байна”² гэжээ.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан шинжлэх ухааныг хөгжүүлэх, боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд шинжлэх ухааны төв байгууллага болох шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль тогтоомж нь тус байгууллагын эрх зүйн байдлыг бүрэн тодорхойлж чадаж байгаа эсэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд аливаа хүндрэл байгаа эсэх, эрх зүйн хийдэл бий эсэх зэргийг судалж, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шаардлагатай байна.

Иймд энэхүү судалгаагаар “Шинжлэх ухааны эрх зүйн байдлын тухай хууль”-д тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1998 онд Улсын Их хурлаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын их хурлын 204 оны 24 дүгээр тогтоол зэрэгт үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг баталсан байдаг. Уг мастер төлөвлөгөөнд 5 зорилгыг тодорхойлсон бөгөөд 3 дах зорилго нь Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг хамгаалах, ашиглах талаар эрх зүйн орчин, институтийн тогтолцоог бүрдүүлэх болно.

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх хэсэгт “Шинжлэх ухааны академийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна” гэж заасны дагуу Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тогтоосон хуулийн зохицуулалтыг шинэчлэх, сайжруулах асуудлыг зайлшгүй хууль батлан гаргах замаар хэрэгжүүлэх тул Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын³ /цаашид “аргачлал” гэх/ 5.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонголоо.

¹“Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” төслийн баримт бичиг. БСШУЯ. УБ., 2006. 25 дахь тал

²“Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” төслийн баримт бичиг. БСШУЯ. УБ., 2006. 31 дэх тал

³Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

Иймд урьдчилан тандан судлах ажиллагааг гүйцэтгэхдээ аргачлалын 2.1-д заасан 2 дахь үе шатнаас эхлүүлэн дараах дарааллын дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 1) Асуудалд дүн шинжилгээ хийх
- 2) Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох /аргачлалын 2.1.2/;
- 3) Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах /аргачлалын 2.1.4/;
- 4) Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх /аргачлалын 2.1.6/.
- 5) Зөвлөмж боловсруулах

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль”-д үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх, социологийн судалгаа авах мөн өмнө хийгдсэн социологийн судалгаа, бусад статистик мэдээллийг ашигласан болно. Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томьёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж, хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч, үр нөлөөг судалсан. Эцэст нь тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль 1996 онд батлагдаж, 2006 онд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойш 21 жил болж байна. Монгол улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2-р зүйлд “*Монгол Улсын шинжлэх ухааны академи нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн.*” гэж тодорхойлсон байдаг. Уг тодорхойлолт нь шинжлэх ухааны академийн статустай нийцэж байна уу гэдгийг тодруулахаар экспертүүдийн дунд судалгаа явуулсны үр дүнд нийт судалгаанд оролцогсдын 50 хувь нь “шинжлэх ухааны академийн статустай нийцэхгүй байна”, 15 хувь нь “мэдэхгүй”, үлдсэн 32 хувь нь “шинжлэх ухааны академийн одоогийн статуст нийцэж байгаа, олон улсын жишигтэй нийцэж байгаа” гэсэн байна⁴.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2-р зүйлд “.... *Академи нь төрийн ивээлд байна*” гэж заасан нь шинжлэх ухааныг зөвхөн академиар хязгаарлан авч үзсэн мэт болсон, хувийн статустай шинжлэх ухааны байгууллага, нэгжийг орхигдуулсан, ер нь шинжлэх ухаан бүхэлдээ төрийн ивээл, хамгаалалтад байж чадахгүй байгаа гэдэгтэй судалгаанд оролцогсдын 37,1 хувь нь бүрэн санал нийлж, 48,6 хувь нь зарим талаар тэгж үзэж болох юм гэж⁵ хариулжээ.

Судалгаанд оролцсон экспертүүдийн дийлэнх олонх нь шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал, статусыг өөрчлөх шаардлагатай буюу шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал, статусыг тодорхой, үр нөлөөтэй болгох шаардлагатай гэдэгтэй санал нийлсэн байна.

⁴ШУА, тэргүүлэгчдийн газар болон ШУА, Философийн хүрээлэн. “Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ”. 2017 он., УБ., 77 дахь тал

⁵ШУА, тэргүүлэгчдийн газар болон ШУА, Философийн хүрээлэн. “Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ”. 2017 он., УБ., 78 дахь тал

Эрх зүйн тайлбар толь бичгийг шүүн үзэхэд “төв байгууллага” гэх нэр томъёоны тайлбар байхгүй бөгөөд мөн “төрийн ивээлд байна” гэх зохицуулалтын агуулга нь мөн тодорхойгүй, тунхгийн шинжтэй байна. Иймд төрийн аль субъект, ямар чиглэлд хэрхэн ивээхийг тодорхой хуульчлах шаардлага байгаа бөгөөд ингэснээр шинжлэх ухааны салбарын алсын хараа, эрхэм зорилго, түүнд хүрэх зорилтууд, түүний хүрээнд хийгдэх үйл ажиллагааны цар хүрээ илүү тодорхой, нарийн чигтэй болж улмаар салбарын хууль тогтоомжуудыг батлахад боловсруулж байсан үзэл баримтлал дахь зорилго практикт хангагдах нөхцөл бүрдэхээр байна.

“Эрх зүйн байдал” гэдэг нь эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон субъектийн эрх ба үүргийн цогц⁶ гэж эрх зүйн тайлбар тольд тодорхойлсон байдаг. Уг тодорхойлолтын дагуу шинжлэх ухааны эрх зүйн байдлын тухай хуульд шинжлэх ухааны академийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага маш тодорхой тусгагдсан байхаас гадна уг эрх, үүрэг ньхэрэгжүүлэх бүрэн боломжтой байх шаардлагатай. Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7-р зүйлд академийн эдлэх эрх, хүлээх үүргийг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

1. Академи нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

- 1/ хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах;
- 2/ харьяа нэгж, лабораторийн үйл ажиллагааг зохицуулах, улсын захиалгатай судалгааны ажлыг үр дүнтэй гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
- 3/ улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- 4/ шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах;
- 5/ шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадалгаа хийх;
- 6/ салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- 7/ эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

4. Академи нь дараах эрхийг хэрэгжүүлнэ:

- 1/ эзэмшилдээ байгаа өмч хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг зохих хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;
- 2/ эрдэм шинжилгээний бүтээл, ном, сэтгүүл хэвлэж нийтлэх;
- 3/ гадаад орны шинжлэх ухааны байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- 4/ өөрийн нэрэмжит шагнал бий болгож, түүний санг байгуулах.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар шинжлэх ухааны академийн эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож өгөөгүй байна. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны академи нь шинжлэх ухааны төв байгууллага болохын хувьд шинжлэх ухааны аль салбарт ямар бодлого баримтлах мөн салбарын эрдэм шинжилгээний ажил, түүний үр дүнг хэрэглээнд оруулах, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийн төсөл дэх судалгаа, шинжилгээний ажлын хэрэглээг тогтворжуулах чиглэлд ямар үйл ажиллагаа эрхлэх талаар зохицуулалт одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй

⁶С.Нарангэрэл. “Монголын эрх зүйн толь бичиг” дөрөв дэх хэвлэл. 2015 он., УБ., 660 дахь тал

шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдаагүй байна. Тиймээс шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5-р зүйлд заасан шинжлэх ухааны академийн удирдах дээд байгууллагын хэлэлцэх асуудлуудаас шинжлэх ухааны академийн эрхлэх үйл ажиллагааг түүвэрлэн авч үзэв. Ийнхүү үзэхэд шинжлэх ухааны академийн эрхлэх үйл ажиллагаа нь:

- Шинжлэх ухаан, технологийн тодорхой салбар, чиглэлийг хөгжүүлэхэд засгийн газарт дэмжлэг үзүүлэх;
- Эдийн засаг, нийгмийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж, УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих;
- Судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх
- Дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргах
- Хэвлэлд шилжүүлэх ном, эрдэм шинжилгээний материалыг шүүн хэлэлцэх
- Эрдэмтийг шагналд тодорхойлох болон шинжлэх ухааны академийн дотоод бүтэц, зохион байгуулалттай холбоотой бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр хязгаарлагдаж байна.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д “Яам нь засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн” гэж заасан мөн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д “Агентлаг нь засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага” мөн гэж тус тус тодорхойлсон байна. Үүнээс харахад шинжлэх ухааны төв байгууллага гэж шинжлэх ухааны үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн байгууллага гэж ойлгогдохоор байна. Гэтэл хуульд ШУА-ийг зөвхөн зөвлөмж гаргах, зөвлөх эрхтэй оролцох гэх мэтчилэн идэвхгүй үйл ажиллагаатай байхаар хуульчилсан байгаа нь шинжлэх ухааны талаар төрөөс баримтлах бодлого, түүний хэрэгжилтэд зарим ойлгомжгүй байдлыг үүсгэж, шинжлэх ухааны хөгжилд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2016 оны жилийн эцсийн статистик мэдээгээр эрдэм шинжилгээний байгууллагад 3502 хүн ажиллаж байсан бөгөөд үүний 2221 нь эрдмийн зэрэг цолтой ажиллагсад байжээ (шинжлэх ухааны доктор 77, боловсролын доктор 432, академич 32, профессор 77, дэд профессор 74)⁷. Шинжлэх ухааны байгууллагад ажиллагсдын тоог нийт хүн амтай харьцуулбал 1 сая хүнд ойролцоогоор 995 эрдэм шинжилгээний ажилтан ногдох бөгөөд дэлхийн дундаж /1500 орчим⁸/ үзүүлэлтээс 33,6 хувиар бага байна. Хэрэгцээт боловсон хүчнээр хангах бодлого алдагдаж, боловсон хүчнийг дэмжих, ажиллах нөхцөл боломжоор хангах, нийгмийн асуудлыг анхаарах, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сургах, бэлтгэх үйл явц удаашрах, хоцрогдох, тасалдах байдал шинжлэх ухааны салбарын нэг гол дутагдал болж байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дахь хэсэгт “Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулахад нэн түрүүн чиглүүлэх, оюуны

⁷http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=dt_nso_2002_006v1&cs003_select_all=0&cs003singleselect=_2&year_select_all=0&yearsselect=_2016&viewtype=table

⁸Н.Одонгарав. “Ямба, ял хоёрыг нь үүрүүлж” шинжлэх ухааны “эрх чөлөөг” хангах нь Монгол Улс хөгжих гол гарц мөн. Нийтлэл. 2016.10.24. <http://mas.ac.mn/>

шинэ бүтээлийн эрэлтийг нэмэгдүүлж, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, капитал болгоход чиглэсэн бодлогыг цогцоор хэрэгжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд уг зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулж, тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгажээ.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар авч үзсэн болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

- Хуульд заасан шинжлэх ухааны академийн тодорхойлолт нь оновчтой томъёологдсон эсэх нь эргэлзээтэй байна;
- Хуульд шинжлэх ухааны академийн хэрэгжүүлэх чиг үүрэг болон эдлэх эрхийг тодорхой тусгаж өгөөгүй байна;
- Хуульд академийн тэргүүлэгчдийн эдлэх эрх, хүлээх үүргийг тусгаж өгөөгүй буюу эрх зүйн хийдэл бий болон байна;
- Хуульд зааснаар шинжлэх ухааны академи нь эрдмийн зэрэг, цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэж заасан ч практикт уг зохицуулалт хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй, хэрэгжилт бүрэн хэмжээнд хангагдахгүй байна;
- Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой тусгаагүй, зөвлөх, дэмжлэг үзүүлэх зэрэг идэвхгүй чиг үүрэгтэй байхаар зохицуулсны улмаас тус байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, ач холбогдол буурч байна;

Эдгээр асуудлуудын хүрээнд судалгааны цар хүрээг одоогийн байгаа тогтолцоог сайжруулах, “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг боловсронгуй болгох, академийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгож, академийн эрх бүхий байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгон эрх, үүргийг тусгайлан зааж өгөх, академийг чиг үүргээ хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангах гэж тодорхойлов.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох⁹

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

⁹Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

Эрх ашиг хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Шинжлэх ухааны академи	Шинжлэх ухааны академийн үйл ажиллагаа, түүний чиг үүрэгтэй холбоотой асуудал нь Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиас шууд хамааралтай байна. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал, чиг үүргийг зохистойгоор хуульчлаагүй нь түүний үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлж байгаа юм.
2	Шинжлэх ухааны академийн бүтцийн байгууллагууд /Их чуулган, Бага чуулган, тэргүүлэгчид, тэргүүлэгчдийн ажлын алба/	Шинжлэх ухааны академийн бүтцийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, эрх, үүргийг шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд бүтцэд хамаарах байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхой хуульчлаагүйн улмаас хуулийн хийдэл бий болох, үр нөлөөгүй байдал үүсэх зэргээр тус байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.
3	Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэн, төв, лаборатори, бусад нэгжүүд	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын хуульд шинжлэх ухааны академи өөрийн харьяа хүрээлэн, төв, лаборатори, бусад нэгжүүдтэй байж болно гэж зохицуулсан боловч уг байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаар тодорхой зохицуулалтыг тусгаагүй байгаа нь академийн харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон байдал

“Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль”-д үүсэж буй зарим асуудлын шалтгаан нөхцөлийг дараах байдлаар багцлан авч үзэв.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлыг тодорхойлоход оршиногэж заасан боловч хуульд шинжлэх ухааны академийн хэрэгжүүлэх чиг үүргийн цар хүрээг тодорхойлоогүй, чиг үүрэг болон бүрэн эрхийг ялгахгүйгээр 7 дугаар зүйлийн 7.1-д бүхэлд тусгасан, шинжлэх ухааны академийн бүтцэд хамаарах байгууллага, албан тушаалтнуудын эрх, үүргийг хуульчлаагүй зэрэг нь шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тодорхойгүй болгож, хуулийн зорилт хангагдахгүй байх нөхцөлд хүргэж байна.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д Академи харьяандаа өөрийн чиг үүрэг, зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори, бусад нэгж ажиллуулж болно гэж зохицуулсан байдаг боловч уг харьяа байгууллагууд ямар эрх, үүрэгтэй байхыг хуульд тодорхойлоогүй мөн уг харьяа байгууллагуудын эрх зүйн байдлыг

хэн тодорхойлохыг зохицуулсан зүйл байхгүй байна. Хуульд зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн хийдлийг бий болгох, тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгох нөхцөлд хүргэж байна.

Дээрхээс дүгнэн үзвэл Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалтууд нь зөрчилтэй, хийдэлтэй, бодит хэрэгцээ шаардлагад нийцэхгүйн улмаас хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, үр нөлөөгүй байх үр дагаварт хүргэж байна гэж ойлгож болох юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хэдийгээр манай улсад “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж байгаа буюу шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал тодорхойлогдож, түүний бүтэц, зохион байгуулалт болон хэрэгжүүлэх эрх, үүрэг нь тодорхой болох нөхцөл бүрдсэн ч дээр дурдсан эрх зүйн асуудал болон нийгмийн бодит хэрэгцээ шаардлага үүссээр байна. Өөрөөр хэлбэл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодит хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хангах”

Энд дурдсан зорилгын хүрээнд асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

Зорилт:

- Монгол Улсын Үндсэн хуульд “..... шинжлэх ухаан төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу шинжлэх ухааны төв байгууллага болох шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлж, үйл ажиллагаандаа баримтлах бодлого, зарчим, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлох;
- Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинжлэх ухааны академийн Их Чуулган, Бага Чуулган, Академийн тэргүүлэгчид, ерөнхийлөгч болон гишүүдийг эрх, үүргийг тодорхойлох;
- Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг үр нөлөөтэй болгох арга замуудыг тодорхойлох;

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ТҮҮНИЙҮР НӨЛӨӨ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хангах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг, сөрөг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Зардал зохих хэмжээнд шаардагдана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Шинжлэх ухааны эрх зүйн байдлыг тогтоосон тул зах зээлийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх замаар шийдвэрлэх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тодорхой болгоход тодорхой санхүүжилт шаардлагатай ч хуулиар тогтоосон зохицуулах харилцааг өөрчлөх боломжгүй	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг	Шинжлэх ухааны академи нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага бөгөөд шинжлэх ухааны төв байгууллага тул уг байгууллагын эрх зүйн байдлыг сайжруулах, шинжлэх ухааны	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

	үүргийг гүйцэтгүүлэх	академийн хэрэгжүүлэх чиг үүргийн үр нөлөөг нэмэгдүүлэх асуудлыг аливаа төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлснээр шийдвэрлэх боломжгүй.	чадахгүй.	
6	Захиргааны шийдвэр гаргах	Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Шинжлэх ухааны академийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна” гэж заасан тул академийн эрх зүйн байдлыг захиргааны шийдвэрээр тодорхойлох боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Монгол Улс шинжлэх ухааны салбарыг хөхүүлэн дэмжих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох бодлого баримталж байгаатай холбогдуулан эрх зүйн зохицуулалтын нэгдмэл, харилцан уялдаатай байх, хэрэгжих нөхцөл, баталгааг бүрэн хангасан байх зарчмын дагуу шинжлэх ухааны салбарын хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлж, шинжлэх ухааны академийн нийгэмд үзүүлэх үр нөлөө болон нийгэмд эзлэх байр суурь, ач холбогдлыг нэмэгдүүлэх, харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудын харилцан уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Үүнийг шинжлэх ухааны академийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шийдвэрлэх буюу асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тогтоосон хуулийн зохицуулалтыг шинэчлэх, сайжруулах асуудлыг зайлшгүй хууль батлан гаргах замаар хэрэгжүүлэх ¹⁰ тул “Хууль тогтоомжийнхэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹¹/цаашид “аргачлал” гэх/ 5.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонголоо.

¹⁰Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 10 дугаар зүйл

¹¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

Ингэхдээ “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох, чиг үүргийн үр нөлөөтэй байдлыг хангах” зорилгын хүрээнд дараах зохицуулалтын хувилбарыг дэвшүүлэв. Үүнд:

Хувилбар 1. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан шинжлэх ухааны академийн тодорхойлолтыг “Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи /цаашид “Академи” гэх/ нь тус улсад шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төрийн дээд байгууллага мөн” гэж өөрчлөн найруулж, шинжлэх ухааны академи нь төсвийн хөрөнгөөр санхүүжих боловч хараат бусаар, бие даан үйл ажиллагаа явуулах “онцгой статус”-тай байгууллага болох нөхцөл боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах.

Хувилбар 2. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан шинжлэх ухааны академийн тодорхойлолтыг “Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи /цаашид “Академи” гэх/ нь тус улсад шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төрийн захиргааны байгууллага мөн” гэж өөрчлөн найруулж, шинжлэх ухааны академийг Засгийн газрын агентлагийн статустай болгон хэрэгжүүлэх чиг үүргийг хуульд тодорхой тусгах.

Хувилбар 3. Шинжлэх ухааны академийг Их, дээд сургууль, хүрээлэн, төв, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг хамааруулсан бүх эрдэмтдийн нэгдсэн ТББ болгох.

- Нэгдүгээр хувилбарын хувьд хуульд заасан “академи нь төрийн ивээлд байна” гэсэн ойлгомжгүй, тодорхойгүй заалтыг хасаж, Монгол Улсын Үндсэн хуулийн 7-р зүйлийн 7.1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу Шинжлэх ухааны академи нь төрийн хамгаалалтад байж, төрийн байгууллага байх боловч төрийн дээд байгууллага гэж тодорхойлсноор өөрийн эрхлэх асуудлаар хараат бусаар, бие даан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ. Энэ асуудлаар шинжлэх ухааны академи, харьяа байгууллагуудын захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, референтүүдээс авсан судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогсдын 82.5 хувь нь шинжлэх ухааны байгууллага, ажиллагсад нь судалгаа, шинжилгээний ажлын эрх чөлөө бүрэн нээлттэй байж, ажиллах нөөц, нөхцөл боломжийг л төрөөс хангаж байх ёстой гэсэн үзэл бодолд санал нийлсэн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсдын олонх нь шинжлэх ухааны академи нь төрийн хамгаалалтад байх гэхдээ удирдлага, санхүүжилтийн хувьд бие даасан статустай болгох хэрэгтэй гэж үзжээ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8-р зүйлийн 8.1-д зааснаар засгийн газар нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдэл, дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-ийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бөгөөд уг чиг үүргээ яам, агентлагаар дамжуулан хэрэгжүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д заасны дагуу Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн. Мөн хуулийн 18³ дугаар зүйлийн 18³.1-д Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн бүдүүвчийн дагуу байгуулан ажиллуулж болно гэж заасан бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1-д “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх

чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн” гэж тодорхойлсон байна. Дээр дурдсан хуулийн зохицуулалтуудаас харахад хуулийн төсөлд тусгасан “төрийн дээд байгууллага” гэдэг нь яам, агентлагийн статус биш болох нь харагдаж байна. Харин Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19-р зүйлийн 19.2 дах хэсэгт “Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна” гэж заасны дагуу улсын эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар шинжлэх ухааны судалгаа хийж, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлэх, шинжлэх ухаа, технологийн асуудлаар засгийн газарт зөвлөх зэрэг төрийн гүйцэтгэх үүргийг гүйцэтгэж, төсвөөс санхүүжихийн хажуугаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бие даан хараат бусаар гүйцэтгэх, төсвийн бус хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий онцгой статустай байгууллага болох нөхцөл бүрдэх боломжтой юм. Эндээс харахад шинжлэх ухааны академийг төрийн дээд байгууллага гэж тодорхойлон удирдлага, төсвийн бус санхүүжилтийн хувьд хараат бус, бие даасан хэлбэртэй байх талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах энэхүү хувилбар нь үр дүн сайтай, салбарын оролцогчдын эрэлт хэрэгцээг хангаж байгаа тул зохистой хувилбар байж болох юм. Гэхдээ хуулийн энэ хувилбарыг хэрэгжүүлэхийн тулд “төрийн дээд байгууллага” гэсэн нэр томъёог тайлбарлаж, тодорхой болгох нь хамгийн чухал байна.

- Хоёрдугаар хувилбарын хувьд шинжлэх ухааны академийг засгийн газрын бие даасан нэгж болгож, түүний хэрэгжүүлэх чиг үүргийг хуульд тусгайлан зааж өгөх буюу Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 18^{3.1} мөн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийг засгийн газрын агентлагийн статустай болгох юм. Энэхүү хувилбарыг хэрэгжүүлснээр шинжлэх ухааны академи нь засгийн газрын нэгжийн хувьд эрх зүйн байдал нь илүү тодорхой болж, чиг үүрэг нь мөн дэлгэрэнгүй хуульчлагдах бөгөөд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай болно. Тухайлбал хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 35¹ дүгээр зүйлд заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, эрхлэх асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө мөн агентлаг нэгээс илүүгүй орлогч даргатай байх ба агентлагийн орлогч даргыг төрийн албаны төв байгууллагын дүгнэлтийг харгалзан Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө. Түүнчлэн академийн эрх зүйн байдлыг Засгийн газрын агентлагийн тухай хуулиар тогтооно. Энэ хувилбарыг хэрэгжүүлэх тохиолдолд Шинжлэх ухааны академи нь төрийн захиргааны байгууллага болж, эрх зүйн байдал нь эргэлзээгүй тодорхой болох боломжтой болох юм. Салбарын эрдэмтэн, судлаачдын дунд шинжлэх ухааны академи нь оюуны үйлдвэрлэлийн цөм байгууллага учир төрийн хамгаалалтад байх нь зүйтэй хэдий ч төрөөс хараат байх нь шинжлэх ухааны хөгжлийг боомилж байна гэж үзнэ гэсэн үзэл бодол давамгайлж байна¹². Тиймээс хоёрдугаар хувилбарыг хэрэгжүүлснээр эрдэмтэн, судлаачдын эсэргүүцэлтэй тулгарах магадлалтай төдийгүй академи төрийн хяналтад орсноор түүний үйл ажиллагаанд улс төрийн нөлөөлөл орж, гүйцэтгэсэн ажлын үр нөлөө сулрах магадлалтай байж болох юм.
- Гуравдугаар хувилбарын хувьд шинжлэх ухааны академийг төрийн бус байгууллагын статустай болгосноор төрөөс бүрэн хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах, судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх бүрэн эрх чөлөөтэй байх боломж бүрдэх бөгөөд Монгол Улсад

¹²ШУА, тэргүүлэгчдийн газар болон ШУА, Философийн хүрээлэн. “Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ”. 2017 он., УБ., 78 дахь тал

шинжлэх ухааны дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилгыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү хуулбарыг хэрэгжүүлснээр шинжлэх ухааны академи нь улсын төсвөөс санхүүжихгүй буюу өөрийгөө санхүүжүүлэх бөгөөд өөрийн дүрмээр Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагааны цар хүрээгээ чөлөөтэй тодорхойлох эрхтэй болно. Өнөөгийн нөхцөл байдал шинжлэх ухааны академи улсын төсвөөс санхүүжилт авахгүйгээр бие даан үйл ажиллагаа явуулах боломжтой эсэхэд эдийн засаг, санхүүгийн нарийн тооцоолол хийх шаардлагатай. Түүнчлэн шинжлэх ухааны академи ТББ-ын статустай болсноор хуулийн хэрэгжилтийг хангах, академийн чиг үүргийг үр нөлөөтэй болгох зорилго хангагдахгүй байх эрсдэлтэй. Учир нь академи төрийн бус байгууллага болсноор Засгийн газартай ямар ч хамааралгүй болох бөгөөд улсын эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхүйц шийдвэр гаргах эрхгүй болно. Энэ тохиолдолд шинжлэх ухааны академи зөвхөн төрийн захиалгаар судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх байдлаар шинжлэх ухааны асуудлаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаанд оролцох боломжтой болох сул талтай юм.

Иймд дээрх гурван хувилбараас 1 болон 2 дугаар хувилбар судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

Зорилгод хүрэх байдал:

Хувилбар 1. Томьёолол: Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан шинжлэх ухааны академийн тодорхойлолтыг “Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи /цаашид “Академи” гэх/ нь тус улсад шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төрийн дээд байгууллага мөн” гэж өөрчлөн найруулж, хуульд шинжлэх ухааны академи хараат бусаар, бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах.

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох замаар тус байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн улс орон, нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх явдал юм.

Хувилбар 1-ийн хүрээнд шинжлэх ухааны академийг шинжлэх ухааны төрийн дээд байгууллага гэж тодорхойлсноорхуульд уг байгууллагын зөвлөх, дэмжлэг үзүүлэх чиг үүргүүдийг бие даан шийдвэр гаргах, тодорхой үр дагавар бүхий чиг үүргүүдээр сольж, шинжлэх ухааны академийн нийгэм, улс орны хөгжил, эдийн засгийн салбарт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх мөн удирдлага, төсвийн бус санхүүжилтийн хувьд төрөөс хараат бусаар биз даан үйл ажиллагаа явуулах үр дүнд хүрэх боломжтой.

Хувилбар 1-ийн хүрээнд шинжлэх ухааны академийн эрх зүйн байдал, хэрэгжүүлэх чиг үүрэгт өөрчлөлт оруулах тохиолдолд нэн тэргүүнд академид ажиллаж буй этгээдүүдийн цалингийн зэрэглэлийг тодорхой болгох шаардлагатай. Өнөөдрийн байдлаар шинжлэх ухааны академийн ажилтнууд ТҮ зэрэглэлээр цалин авдаг бөгөөд шинэчлэн тогтоох зэрэглэл нь ямар байхаас хамаарч зардал нэмэгдэх эсхүл хасагдах нь тодорхой болох юм. Гэсэн хэдий ч энэхүү хувилбарыг хэрэгжүүлснээр байгууллагын бүтэц, орон тоонд их хэмжээний өөрчлөлт орохгүй байх боломжтой гэж үзэж байгаа тул зардлыг хэмжээ нь харьцангуй бага байна буюу улсын төсөв их хэмжээний ачаалал үүсгэхгүй гэж таамаглаж байна.

Зорилгод хүрэх байдал:

Хувилбар 2. Томьёолол: Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан шинжлэх ухааны академийн тодорхойлолтыг “Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи /цаашид “Академи” гэх/ нь тус улсад шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төрийн захиргааны байгууллага мөн” гэж өөрчлөн найруулж, шинжлэх ухааны академийг Засгийн газрын агентлагийн статустай болгон хэрэгжүүлэх чиг үүргийг хуульд тодорхой тусгах.

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох замаар тус байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн улс орон, нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх явдал юм.

Хувилбар 2-ын хүрээнд шинжлэх ухааны академийг шинжлэх ухааны төрийн захиргааны байгууллага гэж тодорхойлсноор шинжлэх ухааны академи нь засгийн газрын агентлагийн статустай болж, эрх зүйн байдал нь хууль тогтоомжоор тодорхой зохицуулагдана. Түүнчлэн засгийн газрын агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх байгууллага болох тул үйл ажиллагаа нь одоо байгаагаас илүү үр нөлөөтэй, хэрэгжих механизмтай болох боломжтой байна.

Хувилбар 2-ийн хүрээнд шинжлэх ухааны академийг засгийн газрын агентлагийн статустай болгохын тулд Засгийн газрын агентлагийн хуулийн 5-р зүйлийн 5.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайд /цаашид “сайд” гэх/-ын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна” гэж заасны шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай болно. Ийнхүү хууль тогтоомжид өөрчлөлт оруулахад багагүй хэмжээний зардал гарах төлөвтэй байна. Түүнчлэн шинжлэх ухааны академи засгийн газрын агентлагийн статустай болсноор түүний ажилчдын цалингийн шатлал өөрчлөгдөнө. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу шинжлэх ухааны академийн ажилчид төрийн үйлчилгээний зэрэглэлээр цалин тооцдог бөгөөд ТҮ-1 зэрэглэлийн цалин 371,016 төгрөгөөс эхэлж хамгийн өндөр нь ТҮШУ-7 зэрэглэлийн цалин 903,227 төгрөг¹³ байна. Агентлагийн статустай болсноор ажилчид төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний дагуу цалинжих бөгөөд ТЗ-1 зэрэглэлийн цалин 409,323 төгрөгөөс эхэлж, хамгийн өндөр нь ТЗ-14 зэрэглэлийн цалин 978,427 төгрөг¹⁴ байна. Тиймээс энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх нь улсын төсөвт ихээхэн хэмжээний зардал нэмэх үр дагавартай болно.

¹³Засгийн газрын 2014 оны 75 дугаар гогтоолын 3 дугаар хавсралт

¹⁴Засгийн газрын 2014 оны 332 дугаар гогтоолын 1 дүгээр хавсралт

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Дээр дурдсан хувилбаруудад хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, ялгаварлах, гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийг агуулаагүй гэж дүгнэж байна. Харин хувилбарыг хэрэгжүүлснээр шинжлэх ухааны академи нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын асуудлаар зөвлөх үүргийгшийдвэр гаргах хүртэл буюу илүү үр нөлөө бүхий үүрэгтэй байх зохицуулалтыг хуульд тусгаж, уг зохицуулалтыг хэрэгжүүлснээр аливаа асуудлыг шийдвэрлэхдээ шинжлэх ухаанч байр сууринаас хандах, бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах механизм бүрдэх тул Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн баталгаа хангагдах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал хүчин зүйл болно.

2. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Хувилбар 1-ийн хувьд академийн чиг үүргийг өөрчлөн, түүний хэрэгжилтийг хангахад нэмэлт зардал гарах боловч академийн зөвлөх чиг үүргийг шийдвэрийн төсөл гаргах чиг үүрэг болгож, гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн, дүгнэлтийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх зэргээр одоо хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд бага хэмжээний өөрчлөлт оруулах тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангах эхэн үед зөвхөн захиргааны зардал бага хэмжээгээр нэмэгдэх ба бусад зардал их хэмжээгээр нэмэгдэхгүй тул эдийн засагт төдийлөн сөрөг үр нөлөө багатай байна.

Хувилбар 2-ын хувьд Засгийн газар нэг шинэ агентлаг бий болгох учраас нэгдүгээрт захиргааны зардал нэмэгдэнэ, хоёрдугаарт шинжлэх ухааны академийн ажилчдын цалингийн шатлал, зэрэглэл нэмэгдэх тул цалингийн зардлын хэмжээ нэмэгдэнэ. Тиймээс улсын төсвөөс гарах зардал нэмэгдэх сөрөг үр дагавартай.

Хувил 1 болон 2-ын аль аль нь иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй.

3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор шинжлэх ухааны академи нь нийгмийн хөгжлийн бодлогын асуудлаар шийдвэрийн төсөл гаргах үүргийг хуульд тусгаж, аливаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шинжлэх ухаанч байр сууринаас хандах нөхцөл боломжийг илүү нэмэгдүүлэх тул нийгэмд эерэг нөлөөтэй.

4. Байгаль, орчинд үзүүлэх нөлөө

Байгаль орчинд ямар нэг шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого 2016-2030 бодлогын баримт бичгийн үндсэн зорилтуудын нэг нь уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх зэрэг байгаль орчин, хүрээлэн буй орчинтой холбоотой асуудлуудыг дэвшүүлсэн болно. Тиймээс хувилбаруудыг хэрэгжүүлснээр уг зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулж, холбогдох яам, агентлагуудад шийдвэрийн төслийг илгээх зэргээр төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах боломж бүрдэх тул байгаль, орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “...шинжлэх ухаан .. төрийн хамгаалалтад байна” мөн 16 дугаар зүйлийн 16.8-д “Монгол Улсын иргэн шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхтэй” гэж тус тус заасан байдаг.

Тиймээс шинжлэх ухааны академи нь тус улсад шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий төрийн дээд байгууллага байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн байна.

Монгол Улс 2016 оны байдлаар 266 олон талт олон улсын гэрээнд нэгдэн орж, соёрхон баталж, 1118 гаруй хоёр талт олон улсын гэрээг байгуулжээ. Үүнээс шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаатай шууд холбогдох НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, сочлын байгууллагын дүрэм, Эдийн засаг, нийгэм, сочлын эрхийн пакт, зохиогчийн эрхийн тухай, дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц зэрэг 15 гаруй олон талт гэрээнд нэгдэн оржээ. Энд дурдсан олон талт олон улсын гэрээ конвенцийн заалттай зөрчилдсөн зүйл байхгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны 3-р хэсэгт зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээрх хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд шинжлэх ухааны академи төрийн байгууллагань төрийн байгууллага мөн бөгөөд шинжлэх ухааны асуудлыг шийдвэрлэх дээд байгууллага болгох буюу академийн зөвлөх чиг үүрэг бүхий идэвхгүй үйл ажиллагааг шийдвэр гаргах хэмжээнд хүргэж, үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой болно. Түүнчлэн хуульд эрх зүйн байдлыг тодорхойлох замаар академийг удирдлага, төсвийн бус санхүүжилтийн хувьд бие даасан, хараат бус болгох нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлыг тодорхой болгосноор түүний үйл ажиллагаа эрчимжиж, Монгол Улсын шинжлэх ухааны салбарын хөгжилд түлхэц болж, нийгэмд эзлэх байр суурь нь нэмэгдэнэ.

Хувилбар 2-ийн хувьд шинжлэх ухааны академи Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай болж, чиг үүрэг, эрх хэмжээг нь хуульд тусгайлан зааж өгөх бөгөөд ингэснээр хуулийн хийдэл үүсэхгүй байх нөхцөл бүрдэнэ.

Гарч болох сөрөг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн тайлбар тольд “төрийн дээд байгууллага” гэсэн нэр томъёог тайлбарласан, тодорхойлсон зүйл байдаггүй тул шинжлэх ухааны академийг “төрийн дээд байгууллага” гэж тодорхойлсноор уг байгууллагын эрх зүйн байдал нь тодорхойгүй гэж үзэх эрсдэлтэй боловч Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд тус байгууллага нь онцгой статустай болохыг тусгайлан заах замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Хувилбар 2-ийн хувьд шинжлэх ухааны академийг засгийн газрын бие даасан нэгж болгож, түүний хэрэгжүүлэх чиг үүргийг хуульд тусгайлан зааж өгснөөр шинжлэх ухаан хэт төрөөс хараат байх, улс төрийн нөлөөлөлд автах магадлалтай байна. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны академи, түүний ажилтнуудын судалгаа, шинжилгээний ажлын эрх чөлөө бүрэн нээлттэй байх боломжгүй үр дагаварт хүргэнэ.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд энэ чиглэлээр хийгдсэн судалгаа¹⁵-ны мэдээлэлд үндэслэн гүйцэтгэсэн болно.

1.	Австрали (The Australian Academy of Sciences/ Австралийн Шинжлэх Ухааны Академи)	➤ 565 эрдэм шинжилгээний ажилтантай. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4,8%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Засгийн газраас хараат бус бие даасан байгууллагын статустай. ➤ Өөрийн үйл ажиллагаагаа боловсруулан хэрэгжүүлэхдээ ЗГ-аас тодорхой хэмжээний татаас, тэтгэлэг авахыг хуулиар хориглосон. ➤ Академи нь Хойд Америк, Европ, Зүүн Хойд Азийн олон улсын шинжлэх ухаан, технологийн хөгжүүлэх олон улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааны хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлдэг. ➤ Шинжлэх ухааны академиас санаачлан хэрэгжүүлж буй аливаа төсөл хөтөлбөрүүд нь Австралийн Инноваци, аж үйлдвэрийн яам, ЗГ-ын болон олон улсын шинжлэх ухааны хамтын байгууллагаас санхүүждэг.
2.	Хятад (Хятадын Шинжлэх Ухааны Академи/ Chinese Academy of Sciences)	➤ 131,815 эрдэм шинжилгээ, судалгааны ажилтан ажилладаг. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 2.3%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Академи болон түүний хүрээлэнгүүд, харьяа байгууллагуудыг бүхэлд нь академийн Ерөнхийлөгч удирдана. ➤ ШУА-ийн хууль ёсны төлөөлөгч болон гүйцэтгэх удирдлага

¹⁵Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ /хууль эрх зүйн социологийн шинжилгээ/ -2017 он

		нь ШУА-ийн эрдэм шинжилгээний салбаруудын Тэргүүлэгчдийн хурал байна. ➤ ШУА-ийн ерөнхийлөгч нь ажлаа Төрийн Зөвлөл буюу засгийн газрын өмнө шууд хариуцан тайлагнана. ➤ Төрийн санхүүжилтээр байгуулагдсан шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь судалгаа шинжилгээ, технологийн нөөц баялгийг ашигтай, үр бүтээлтэйгээр хуваалцах, ашиглах механизмыг бүрдүүлдэг. ➤ Улсаас, төрийн мэдлийн бус байгууллагууд бие даан шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэн байгуулахыг дэмжиж ажиллах ба тэдний хууль ёсны эрх, ашгийг баталгаажуулна. ➤ Төрийн бус байгууллагуудын байгуулсан шинжлэх ухаан судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь хуулийн дагуу улсаас санхүүжиж буй аливаа судалгаа шинжилгээний төсөл, хөтөлбөрүүдэд тэгш эрхтэйгээр оролцох, өрсөлдөх эрхтэй.
3.	Солонгос (Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Шинжлэх Ухааны Академи/ The National Academy of Sciences)	➤ Нийтдээ 150 орон тооны гишүүдтэй. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4.1%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг ➤ Үндэсний ШУА, түүний харьяа хэлтсүүд нь төрөөс шууд санхүүждэг. ➤ ШУА-ийн үйл ажиллагаанд шаардлагатай нарийвчилсан үйл ажиллагааны дүрмийг Ерөнхий ассамблейгаас батлан хэрэгжүүлнэ. ➤ ШУА нь 1986 оноос судалгаа, шинжилгээний төсөлт ажилд тэтгэлэг олгох, гадаад болон дотоодын эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зорилгоор Судалгааны санг байгуулсан. ➤ ШУА-ийн Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг Ерөнхий Ассамблейгаас 2 жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа улируулан томилох боломжтой. Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны хэлтэс, Байгалийн шинжлэх ухааны хэлтсийн захирал, хэсгийн дарга нарыг тухайн хэлтсийн болон хэсгийн нийт гишүүдээс сонгогдсон хүнийг 1 жилийн хугацаатай томилж мөн 1 удаа улируулан сонгож болно.
4.	Боливи (Боливийн Үндэсний Шинжлэх Ухааны Академи/ National Academy of Sciences in Bolivia)	➤ 250 орчим эрдэм шинжилгээ болон судалгааны ажилчидтай. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4,9% ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Үндэсний шинжлэх ухаан, түүний харьяа хүрээлэн эрдэм

		шинжилгээний төвүүд нь хараат бус бие даасан статустай ➤ Боливийн Үндэсний Сангийн хорооноос санхүүжихийн зэрэгцээ залуу судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтнуудад жил бүр Үндэсний ШУА-иас грант төсөл хэрэгжүүлэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй
5.	Герман (Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Германы ШУА-ийн холбоо/ Union of German Academies of Sciences and Humanities)	➤ 2000 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажилтантай, академийн гишүүд жинхэнэ мөн сурвалжлагч гэсэн 2 төрлийн гишүүнчлэлтэй. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4,6%-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Холбооны санхүүжилт нь төсвийн хоёр эх үүсвэрээс бүрддэг.Төрийн санхүүжилт мөн холбооны өөрсдийн үйл ажиллагааны орлогоор санхүүжнэ.
6.	Грек (Грекийн үндэсний Шинжлэх Ухааны Академи/ Academy of Athens)	➤ 1000 орчим эрдэм шинжилгээ, судалгааны ажилтан ажилладаг. Төсвийн зарцуулалтын 3.1%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Академи нь шууд засгийн газрын харьяа бөгөөд түүний санхүүжилтийг Засгийн газар бүрэн хариуцна. ➤ ШУА-ийн нийт санхүүжилтийн 15%-ийг гэрээслэл, хувьцааны ногдол ашиг болон бусад хараат бус эх үүсвэрээс санхүүжүүлдэг. ➤ Мөн түүнчлэн академи нь гэрээслэл болон бусад төрлийн хандив зэргээс цуглуулсан хөрөнгийн эх үүсвэрээс оюутнуудад эрдэм шинжилгээний тэтгэлэг өгөх, мөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг санхүүжүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Боловсрол, Шашин судлалын яаманд шууд харьяалагдана
7.	Их Британийн Нэгдсэн Вант Улс (Их Британийн Шинжлэх ухааныг дэмжих Эзэн хааны нийгэмлэг/Royal Society Overview)	➤ Нобелийн шагналтай 65 эрдэмтэн нийтдээ 1300 эрдэмтэн, судлаачидтай үйл ажиллагаагаа явуулж байна. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4,7%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Засгийн газраас хараат бус байгууллага. Эзэн хааны шинжлэх ухааны нийгэмлэг, түүний харьяа салбар судалгааны хүрээлэн төвүүдийг тус нийгэмлэгээс томилогдсон 21 судлаач эрдэмтдээс бүрдсэн Зөвлөл удирдана. Тус Зөвлөл нь нийгэмлэгийн бизнесийн үйл ажиллагаа болон Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүдээс хандивласан хөрөнгө мөнгийг хууль дүрмийн дагуу захиран зарцуулах эрхтэй. Нийгэмлэгийн дотоод журам болон нийгэмлэгийн талаар баримтлах баримт бичигт заасанчлан дүрэмдээ өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байна.
8.	Казакстан (Бүгд Найрамдах Казакстан Улсын Үндэсний	➤ Нийт 500 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачид ажилладаг.

	Шинжлэх Ухааны Академи/ National Academy of Sciences of the Republic of Kazakhstan)	➤ Төсвийн зарцуулалтын 4,4%-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд нь төрөөс шууд санхүүжих ба суурь судалгааны сэдвийг Академиас сонгон шалгаруулж ШУА-ийн салбарын ээлжит чуулганд танилцуулна. Академи сонгогдсон судалгааны сэдвийг санхүүжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцаж ажиллана.
9.	Латви(Латви Улсын Шинжлэх ухааны Академи/ Latvian Academy of Sciences)	➤ Нийт 1000 орчим эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачид ажилладаг. ➤ Академи нь шинжлэх ухааны 4 салбарт хуваагддаг бөгөөд салбар бүр тухайн салбарын бага чуулгантай бөгөөд үндсэн үйл ажиллагаагаа Латвийн ШУА-ийн нэгдсэн чуулганд тайлагнадаг. ➤ Төсвийн зарцуулалтын 6,8 %-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ ШУА нь хагас төсвийн санхүүжилттэй байгууллага бөгөөд санхүүжилтийн зарим эх үүсвэрийг олон улсын төсөл хөтөлбөрүүдэд оролцох замаар гаднын улс орнуудын шинэ технологи, ололтуудыг нутагшуулах, мөн өндөр өртөг бүхий инновацийн төслүүдийг хэрэгжүүлэх замаар санхүүжүүлдэг байна. ➤ Төсвийн тусгай гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгийг хандив тусламж, байгалийн баялгаас хуваарилсан ногдол ашиг зэрэг бусад эх үүсвэрээс олдог. ➤ ШУА-нь жинхэнэ болон сурвалжлагч гадаад гишүүнтэй байж болно. ➤ 1992.02.14- ний өдөр Парламентаас батлагдсан Латвийн “ШУА-ийн эрх зүйн байдлын тухай” хуулийн дагуу Академийн Их чуулганаар тус улсын шинжлэх ухаан, судалгааны ажлыг гүйцэтгэх чиг үүрэгтэй. Тус улсын Парламентаас 2014-2020 он хүртэлх Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа тус улсын шинжлэх ухааны салбар, түүний судалгаа хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг ДНБ-ний 1.5-иас доошгүй хэмжээнд санхүүжүүлнэ хэмээн хуульчлан баталсан байдаг.
10.	Оросын Холбооны Улс (Оросын Холбооны Улсын Шинжлэх Ухааны Академи, Russian Academy of Sciences)	➤ Нийтдээ 99.500 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид ажилладаг. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 3,5%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ ШУА төрийн санхүүжилтээр бүрэн санхүүжих бөгөөд суурь судалгааны сэдвийг Академийн зүгээс сонгон шалгаруулж, улмаар ШУА-ийн ээлжит чуулганаар танилцуулсан

		судалгааг санхүүжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцна. ОХУ-д шинжлэх ухааны байгууллагын эрх зүйн байдлыг дараах үндсэн эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулж байна. ➤ ШУА нь өөрийн харьяандаа их сургууль, дунд сургуулиуд байгуулсан байна.
11.	Польш (Польшийн Шинжлэх Ухааны Академи, Polish Academy of Sciences)	➤ 5500 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажилтантай. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 5,4 %-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг ➤ ШУА, түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь улсын төсвөөс шууд санхүүжихийн зэрэгцээ,ЭХ-ны болон бусад хандивлагч, донор улсуудын эрдэм шинжилгээ, сургалтын тусгай сангуудаас санхүүждэг. ➤ Польшийн ШУА-ийн нийт санхүүжилтийн 76,3% нь Польшийн Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагаас, 5.3% нь гадаадын хөрөнгө оруулалт, хандиваас, 17,5% нь бусад эх сурвалжаас бүрддэг байна. ➤ ШУА, түүний хүрээлэнгүүд нь шинжлэх ухааны үр дүнг эргэлтэд оруулах зорилгоор шинжлэх ухааны асуудал хариуцсан сайдын зөвшөөрлөөр хуульд заасны дагуу ашгийн төлөө байгууллагын хувьцааг авах, эзэмшиж болно. Хувьцааны ашиг, хувьцаа худалдсан ашиг нь ШУА, түүний хүрээлэнгүүдийн ашиг байна.
12.	Украин (Украины Үндэсний Шинжлэх Ухааны Академи/ National Academy of Sciences of Ukraine)	➤ Нийтдээ 37.447 ажилтан, албан хаагчид ажиллаж байна. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 4,4%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Үндэсний ШУА болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь шууд улсын төсвөөс санхүүжих бөгөөд судалгаа, шинжилгээний нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож олсон санхүүгийн бусад эх үүсвэрээс санхүүждэг. ➤ ШУА-ийн эрх зүйн байдлын хуулиар тус улсын академи нь бие даасан статустай эрдэм шинжилгээ судалгаа, шинжлэх ухааны төв байгууллага мөн бөгөөд төрийн шууд ивээлд байна. ➤ Хуулийн дагуу ШУА нь жинхэнэ болон сурвалжлагч, гадаад гишүүдтэй байх бөгөөд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй байна.

13.	Франц (Франц Улсын Шинжлэх Ухааны академи/ Academie des Sciences, Institut de France)	➤ ШУА-ийн жинхэнэ гишүүд насан туршдаа сонгогдох бөгөөд нийтдээ 150 жинхэнэ гишүүн, 300 орчим сурвалжлагч гишүүд, 120 гаруй гадаад гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 5,9%-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. ➤ Францын ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд нь тус улсын ЗГ-ын тусгай сан, нарийн бичгийн дарга нарын газар болон бусад агентлагуудаас санхүүждэг. ➤ Академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь Төрийн үйлчилгээний сайдын шууд удирдлага дор ажил үүргээ гүйцэтгэнэ. ➤ Хүрээлэнгүүд нь ажиллаж байгаа ШУА-ийн жинхэнэ болон сурвалжлагч гишүүд, академийн гадаад болон хүндэт гишүүд нь санал хураалтаар сонгогдох бөгөөд сонгууль нь төрийн үйлчилгээний байгууллагуудыг төлөөлж ажиллана.
14.	Шведийн Вант Улс(Шведийн Эзэн хааны нэрэмжит ШУА/ Royal Swedish Academy of Sciences)	➤ Нийтдээ 600 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулдаг. ➤ Төсвийн зарцуулалтын 8%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. Хүрээлэнгийн төсөв, үйл ажиллагааны зардал нь санхүүгийн жилийн гүйцэтгэлээр шийдэгдэнэ. Санхүүгийн жилийн гүйцэтгэлийг Академийн Удирдах зөвлөлд танилцуулж дараагийн жилийн төсвийн төслийг танилцуулна. ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийн санхүүжилт нь ЗГ-ын нийт төсвийн 12%-тай тэнцэх хэмжээний төсвийг төрөөс шууд санхүүжүүлэх бөгөөд төсвийн бусад орлогыг төрийн бус байгууллагууд, олон улсын болон үндэсний хэмжээний тусгай сангуудаас академийн салбар хүрээлэнгүүдийн боловсруулсан төслүүдийг сонгон шалгаруулалтын зарчмаар санхүүжүүлнэ, мөн хувийн салбар, хандивлагчдаас санхүүжнэ. Академийн нарийн бичгийн дарга нарын газар болон түүний харилцаа холбоо, захиргааны болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. ➤ Хараат бус, төрийн бус байгууллагын зарчмаар ажилладаг шинжлэх ухааны нийгэмлэгийн статустай үйл ажиллагаа явуулдаг.
15.	Япон (Японы Шинжлэх Ухааны Академи/ The Japan Academy)	➤ Японы шинжлэх ухааны академи нь Японы Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэдэх “онцгой статус”-тай байгууллага юм. ➤ Тус академийн эрх зүйн байдлыг Японы академийн тухай бие даасан хуулиар зохицуулна. 1949 онд ЗГ-аас шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх зорилгоор “Японы шинжлэх ухааны зөвлөл”-ийг байгуулсан бөгөөд зөвлөл нь төрийн

		болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шинжлэх ухааны салбарын эрдэмтдийг гадаад, дотоодын эрдэмтэдтэй холбох, эрх ашгийг нь хамгаалах, цөмийн аюулгүй байдалтай холбоотой санал, зөвлөмжийг ЗГ, олон нийтэд зориулан гаргаж ирсэн байна. ➤ Японы ШУА нь ерөнхий-2, дэд-7 шинжлэх ухааны салбарт хуваагдаж, ерөнхий болон салбар хуралдаан зохион байгуулдаг. Академийн Ерөнхий хуралдаанаар академитай холбоотой чухал асуудлаар шийдвэр гаргадаг бол салбар хуралдаанаар тухайн салбарын цаг үеийн болон шаардлагатай асуудлаар хуралдаж, шийдвэр гаргадаг. ➤ Академи нь ажлын албатай бөгөөд нарийн бичгийн дарга болон хэд хэдэн туслах ажилтантай. Эдгээр ажилчид нь Академийн Ерөнхийлөгч болон хэд хэдэн туслах ажилтантай. Эдгээр ажилчид нь Академийн ерөнхийлөгч болон албаны бус ажилчдын удирдлага дор Японы ШУА-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна. ➤ Японы шинжлэх ухааны зөвлөл нь тус улсын 840.000 эрдэмтдээс сонгогдсон 2000 гишүүн, 210 зөвлөлийн гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг. Удирдлагуудын Зөвлөл нь Ерөнхийлөгч, 3 дэд Ерөнхийлөгчтэй ба эдгээр удирдлагуудыг зөвлөлийн гишүүдээс томилдог мөн зөвлөлийн 2000 гишүүдийг тус улсын нийт эрдэмтдээс судалгааны бүтээл, ололт амжилтыг үндэслэн зөвлөлийн ерөнхийлөгч сонгоно. ➤ Улсын төсвийн зарцуулалтын 3,5%-ийг боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. 2000 оноос хойш шинжлэх ухааны салбар дахь Нобелийн шагналыг 14 удаа хүртсэн нь тус улсын шинжлэх ухааны салбарын хөгжлийн нэг үзүүлэлт юм. Япон улс 2015 онд улсын нэгдсэн төсвөөс нийт 3.626,9 тэрбум иенийг Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хуваарилсан байх бөгөөд үүнийг дараах байдлаар төсөвлөсөн хуваарилалтаас үзвэл • Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яаманд – 66% • Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яаманд – 14% • Бусад яам, агентлагийн шинжлэх ухаан, технологи, инновацийн зардалд – 20%-ийг тус тус хуваарилсан байна
--	--	--

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Монгол Улсын шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд болон экспертүүдээс авсан судалгааны үр дүн (судалгааны үр дүнг дор хүснэгтээр харуулав)-д шинжлэх ухааны цөм байгууллага болох шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, академийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох бодит хэрэгцээ, шаардлага нийгэмд байна.

Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг үнэлэх судалгааг гүйцэтгэж, дор дурдсан үр дүн гарсан байна. Үүнд:

Тайлбар: Маш муу - /1-2/, Муу /3-4/, Дунд /5-6/, Сайн /7-8/, Маш сайн /9-10/ оноогоор үнэлүүлж, дундаж утгыг тооцож гаргав¹⁶.

Үүрэг	Дундаж утга
Мэдлэг, чадавх бий болгох, түгээх	5.96
Судалгааны ажлын үр дүнг мэдээлэх, дамжуулах	5.66
Шинэ бүтээгдэхүүн, технологийн судалгаа явуулах, хөгжүүлэх	5.25
Улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдлыг ШУ-ны үүднээс дүгнэж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлох	4.61
Шинэ бүтээл, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх	4.44
Төрд зөвлөх, бодлого тодорхойлох	4.25
Улс орны томоохон төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх	4.08
Улс орныг удирдан чиглүүлэх	3.34

Дээрх судалгааны үр дүнгээс харахад шинжлэх ухааны академийн үүргийн гүйцэтгэл 50 хувьтай буюу муу үнэлгээтэй байгаа тул хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, ач холбогдолтой болгох хэрэгцээ, шаардлагатай байна. Иймд Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох асуудлаар дараах зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

1. Шинжлэх ухааны академи “төрийн ивээлд байна” гэх зохицуулалтын агуулга нь тодорхойгүй, тунхгийн шинжтэй байна. Иймд төрийн аль субъект, ямар чиглэлд хэрхэн ивээхийг тодорхой хуульчлах шаардлага байгаа бөгөөд ингэснээр шинжлэх ухааны салбарын алсын хараа, эрхэм зорилго, түүнд хүрэх зорилтууд, түүний хүрээнд хийгдэх үйл ажиллагааны цар хүрээ илүү тодорхой, нарийн чигтэй болж улмаар салбарын хууль тогтоомжуудыг батлахад боловсруулж байсан үзэл баримтлал дахь зорилго бодитоор хангагдах боломж бүрдэхээр байна.
2. Шинжлэх ухааны академийн статусыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах
3. ШУА-ийн үйл ажиллагааны хүрээг Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой тусгаагүй байна. Тиймээс академийн үйл ажиллагааг үр нөлөөтэй болгох үүднээс түүний чиг үүргийг хуульчлах нь зохистой бөгөөд одоогийн хуулиар зохицуулсан зөвлөх, дэмжлэг үзүүлэх гэсэн идэвхгүй чиг үүргүүдээс гадна шийдвэр гаргах, дүгнэлт гаргах

¹⁶ШУА, тэргүүлэгчдийн газар болон ШУА, Философийн хүрээлэн. “Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ”. 2017 он., УБ., 92 дахь тал

зэрэг илүү үр нөлөө бүхий, нийгэмд үзүүлэх ач холбогдолтой чиг үүргийг тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна.Түүнчлэн ШУА-ийн үндсэн чиг үүрэгт “иргэдийг соён гэгээрүүлэх, төрийн төв байгууллагад шинжлэх ухааны мэдээллээр үйлчлэх” гэж оруулж болох юм.

4. Шинжлэх ухааны академийн бүтэц, зохион байгуулалтад хамаарах бүх субъектүүдийн (эрдэм, шинжилгээний байгууллага, Их хурал, Бага хурал, Академийн тэргүүлэгчид, Академийн гишүүд) эдлэх эрх, хүлээх үүргийг хууль тодорхой тусгах.
5. Шинжлэх ухааны доктор зэрэг хамгаалах, олгох журмыг батлах эрхийг Шинжлэх ухааны академи , түүний бүтцийн байгууллагад өгөхөөр хуульд тусгах.
6. ШУА-ын ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зохицуулсан 8 дугаар зүйлд шинжлэх ухааны салбарын хөгжил болон төрийн бодлого, шийдвэр гаргах, эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл хөтөлбөрүүдэд шинжлэх ухааны холбогдох салбар, хүрээлэнгүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээнд хуульчлах
7. ШУА-ын статус, эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох

Эцэст нь энэхүү судалгаанд дурдагдсан асуудлуудаас үзэхэд шинжлэх ухааны академийн талаар эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх бодитой шаардлага байна. Энэ хэрэгцээ шаардлагыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

**Хавсралт-1: Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд
үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхалтыг хориглож буй зохицуулалт агуулаагүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал бий болгосон зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээнд харшилсан зохицуулалт агуулаагүй.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, референт, БСШУСЯ-ны холбогдох мэргэжилтэн, судлаачдын саналыг тусгаж ажиллав.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа эсхүл хөндөгдөж болзошгүй иргэд байхгүй.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил	Тийм	Үгүй	

	гарах эсэх			
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээ конвенцэд нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Шинжлэх ухааны академи үйл ажиллагааныхаа хүрээнд хууль зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	- Их Чуулган - Бага Чуулган - Академийн тэргүүлэгчид - Ерөнхийлөгч - Академийн гишүүд
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх,	Тийм	Үгүй	

	гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шинжлэх ухааны академийн удирдах байгууллагууд үүрэг хүлээнэ.
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тусгагдана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Бүх нөхцөлд жендерийн тэгш байдлыг хангах нөхцөл агуулгаар тусгагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөөг	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж байгууллага болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгж байгууллагад бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Аж ахуйн нэгж	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгж	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

байгууллагын үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	байгууллагад шинээр зардал үүсэх эсэх			
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа, бүтээгдэхүүнийг заавал худалдан авах шаардлага бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, хориг тавих эсэх	Тийм	Үгүй	сөрөг нөлөөгүй
	3.5.Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа зогсоох нөхцөл байдал бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэх захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал /мэдээлэл, тайлан гаргах г.м/ бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг /үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг г.м/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Инноваци болон судалгаа, шинжилгээ	6.1.Судалгаа, шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	7.4.Хувь хүний болон гэр бүлийн санхүүгийн байдалд /шууд буюу урт хугацааны туршид/ нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шинээр дипломын дараах сургалт явуулах сургууль байгуулах ажлыг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Шинжлэх ухааны академийн харьяа дипломын дараах сургалт явуулах сургууль байгуулах шаардлагатай.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эергээр нөлөөлөх боловч улсын төсөвт тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг байдлаар зөрчилдөхгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөөг	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Шинээр сургууль байгуулахтай холбогдуулан ажлын байр шинээр бий болох боломжтой.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдлыг үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх /эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнх г.м/	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Гадаадын иргэдэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шинжлэх ухааны академийн чиг үүрэг, үйл ажиллагаанд зохих өөрчлөлт орно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	4.4.иргэдийн шүүхэд хандах, эрх бүхий байгууллагад гомдол гаргах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн, нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхүйц дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ г.м/-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.3.Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн байгууллага/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	эсэх			
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөөг	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Тээврийн хэрэгслийн хэрэглээний улмаас агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Ан, амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Газар ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Нөхөн сэргээгдэх /сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж, бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль, 1996 он.
3. Шинжлэх ухаан технологийн тухай хууль, 2006 он.
4. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он.
5. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он
6. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он
7. Төрийн албаны тухай хууль, 2002 он
8. Монгол Улсын Их Хурлын 1998 оны 55 дугаар тогтоол
9. Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоол
10. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
11. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”.
12. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоол
13. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоол
14. Шинжлэх ухааны академийн дүрэм, 1997 он.
15. Шинжлэх ухааны академийн Бага чуулганы ажиллах журам, 2010 он

Хоёр. Судалгааны ажил, гарын авлага, өгүүлэл, нийтлэл

1. Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газар, Философийн хүрээлэнгийн хамтран гаргасан “Шинжлэх ухааны салбарын хууль, эрх зүйн орчны шинжилгээ” судалгааны тайлан, дүн шинжилгээ, 2017 он
2. Н.Одонгарав. “Ямба, ял хоёрыг нь үүрүүлж” шинжлэх ухааны “эрх чөлөөг” хангах нь Монгол Улс хөгжих гол гарц мөн. Нийтлэл. 2016.10.24.
3. <http://muls.edu.mn/viewpage/1843>

Гурав. Веб сайт

1. <http://abs.gov.au/ausstats/abs@.nsf/web+pages/population+clock?opendocument/>
2. <http://interacademies.net/academies/byregion/southeastasiapacific/australia.aspx>
3. <https://www.science.org.au/>
4. <http://data.stats.gov.cn/>
5. <http://interacademies.net/academies/byregion/southeastasiapacific/china.aspx>
6. <http://english.cas.cn/>
7. <http://kosis.kr/index/index.jsp>
8. <http://interacademies.net/academies/byregion/southeastasiapacific/13444/13446.aspx>
9. <http://nas.go.kr/eng/active/academic.jsp>
10. <http://ianas.org/index.php/members/78-ianas/169-bolivia>
11. <https://www.leopoldina.org/en/about-us/>
12. <http://www.statistics.gr/el/homeen/statistics/-/publication/SPO18>
13. <http://interacademies.net/academies/byregion/southeasteurope/greece.aspx>
14. <https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/populationandmigration/populationestimates>

15. <https://royalsociety.org/>
16. <http://interacademies.net/academies/byreign/middleeastcentralasia/kazakhstan.aspx>
17. <http://interacademies.net/academies/byreign/Centraleasterneurope/latvia.aspx>
18. <http://www.ras.ru/>
19. <http://interacademies.net/academies/byreign/Centraleasterneurope/Poland.aspx>
20. <http://www.nas.gov.ua/EN/Pages/default.aspx>
21. <http://kva.se/en/startside>
22. <http://www.scb.se/en/>
23. <http://www.japan-acad.go.jp/en/>
24. <http://mas.ac.mn/>
25. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=dt_nso_2002_006v1&cs003_select_all=0&cs003singleselect=_2&year_select_all=0&yearsingselect=_2016&viewtype=table